



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/411/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a></p> <p>Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Г.Долгорсүрэн Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsureng@audit.gov.mn">dolgorsureng@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/235

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНГӨНХУЯГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Дүүргийн Засаг даргын бүрэн эрх, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэх чиг үүрэгт өөрчлөлт ороогүй байхад төсвийн гүйцэтгэл өмнөх оноос 6,467,860.7 мянган төгрөгөөр буюу 33.5 хувиар өссөн байна. Тухайлбал, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал 626,885.6 мянган төгрөгөөр буюу 95.2 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 1,568,827.0 мянган төгрөгөөр буюу 78.1 хувиар, засаг даргын нөөц сан 338,002.2 мянган төгрөгөөр буюу 68.0 хувиар, гадаад томилолтын зардал 90,127.8 мянган төгрөгөөр буюу 30.2 хувиар тус тус өссөн байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/133 дугаар захирамжийг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан Баянгол дүүргийн 10, 22, 23 дугаар хорооны 2200 айл, өрхөд тараасан, бодитоор байхгүй 1,892,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий "Нүүдэлчин эко" зуухыг тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

### **Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 274 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Тайлант онд 12 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан 135,280.0 мянган төгрөгийн зардлыг үйл ажиллагааг сурталчлан таниулахад зарцуулжээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>233,420,666.11</u></b>	<b><u>2,037,713,179.71</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>1,614,213,503.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	<b>1,614,213,503.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	1,614,213,503.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>19,175,227.12</b>	<b>25,890,945.52</b>
34600	Урьдчилж гарсан зардал	7,348,012.12	10,904,677.32
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>11,827,215.00</b>	<b>14,986,268.20</b>
34714	Томилолтын урьдчилгаа	11,827,215.00	14,986,268.20
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>214,245,438.99</b>	<b>397,608,731.19</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>214,245,438.99</b>	<b>397,608,731.19</b>
35410	Бичиг хэргийн материал	16,767,120.00	32,528,600.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,118,350.00
35470	Бусад хангамжийн материал	197,478,318.99	361,961,781.19
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>91,302,230,024.21</u></b>	<b><u>112,371,976,973.62</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>91,302,230,024.21</b>	<b>112,371,976,973.62</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>90,768,243,624.21</b>	<b>111,837,200,573.62</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	66,993,779,546.96	71,177,605,403.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,896,127,763.47)	(32,945,579,779.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,521,651,331.00	640,518,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(499,461,500.07)	(341,417,422.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,725,667,451.50	4,036,095,475.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,325,839,222.52)	(1,779,404,404.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,600,272,089.00	2,121,491,902.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(893,985,763.41)	(794,614,001.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,139,085,937.25	92,592,741,379.72
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,611,890,282.03)	(22,885,327,779.97)
39217	Ном	15,091,800.00	15,091,800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>533,986,400.00</b>	<b>534,776,400.00</b>
39301	Програм хангамж	4,596,000.00	3,806,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,596,000.00)	(3,016,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	533,986,400.00	533,986,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>91,535,650,690.32</u></b>	<b><u>114,409,690,153.33</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,614,213,503.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,614,213,503.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>1,614,213,503.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>1,614,213,503.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,614,213,503.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>91,535,650,690.32</u></b>	<b><u>112,795,476,650.33</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>91,535,650,690.32</b>	<b>112,795,476,650.33</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,449,980,907.16	26,449,980,907.16
51101	Өмч: - төрийн	26,449,980,907.16	26,449,980,907.16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>27,328,984,702.03</b>	<b>48,591,696,200.38</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	27,328,984,702.03	27,331,870,240.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	21,259,825,960.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,756,685,081.13	37,753,799,542.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>91,535,650,690.32</u></b>	<b><u>114,409,690,153.33</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>30,307,231,272.22</b>	<b>59,704,951,904.59</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,824,544,075.47</b>	<b>33,439,792,874.67</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,824,544,075.47</b>	<b>33,439,792,874.67</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,824,544,075.47	33,439,792,874.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	830,000.00	2,284,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,359,960.00	12,278,700.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	10,798,781,805.59	33,349,997,722.47
120001	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/	8,572,309.88	75,232,452.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>19,482,687,196.75</b>	<b>26,265,159,029.92</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>217,605,991.57</b>	<b>529,589,859.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,846,981.71	52,644,362.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	138,595,497.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,035,292.00	338,350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,723,717.86	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,265,081,205.18</b>	<b>25,735,569,170.92</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,265,081,205.18	25,735,569,170.92
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>29,952,163,845.72</b>	<b>36,601,694,579.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,952,163,845.72</b>	<b>36,601,694,579.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>29,220,327,782.72</b>	<b>35,105,006,687.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,386,633,324.52</b>	<b>12,850,742,037.06</b>
210101	Үндсэн цалин	3,417,704,063.00	5,155,967,887.24
210102	Нэмэгдэл	2,054,059,041.60	1,681,321,830.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	978,754,506.40	1,638,991,161.50
210104	Урамшуулал	833,239,879.52	864,488,488.68
210105	Гэрээт ажлын хөлс	3,102,875,834.00	3,509,972,669.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,411,838,600.00</b>	<b>1,501,446,856.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	993,516,100.00	1,029,039,708.23
210202	Тэтгэмжийн даатгал	104,580,500.00	136,163,622.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	83,664,400.00	66,653,691.49
210204	Ажилгүйдлийн даатгал	20,916,100.00	53,698,544.85
210205	Эрүүл мэндийн даатгал	209,161,500.00	215,891,289.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,552,810,181.83</b>	<b>2,029,446,458.18</b>
210301	Гэрэл, цахилгаан	256,465,360.20	281,219,108.02
210302	Түлш, халаалт	251,990,093.45	284,596,172.84
210303	Цэвэр, бохир ус	74,311,694.84	90,117,574.01
210304	Байрны түрээс	970,043,033.34	1,373,513,603.31
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>561,615,429.97</b>	<b>664,193,756.93</b>
210401	Бичиг хэрэг	213,694,779.00	279,613,210.00

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	71,440,881.88	49,300,168.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,934,519.09	128,271,289.13
210404	Ном, хэвлэл	-	4,808,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	174,545,250.00	145,801,589.00
210408	Бараа материал акталсны зардал	-	56,399,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,203,500.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,203,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>421,068,683.00</b>	<b>430,888,924.00</b>
210604	Урсгал засвар	421,068,683.00	430,888,924.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>331,664,828.90</b>	<b>433,757,300.06</b>
210701	Гадаад албан томилолт	331,126,528.90	385,326,050.06
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	538,300.00	48,431,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,100,132,421.04</b>	<b>2,627,685,914.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,078,430,488.44	2,607,761,739.50
210803	Даатгалын үйлчилгээ	-	813,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	342,204.00	527,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	185,000.00	-
210807	Газрын төлбөр	21,174,728.60	18,583,961.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,429,360,813.46</b>	<b>14,566,845,439.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,911,854,609.58	3,066,343,784.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,517,506,203.88	11,500,501,655.72
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>-</b>	<b>62,944,895.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>-</b>	<b>62,944,895.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	62,944,895.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>731,836,063.00</b>	<b>1,433,742,997.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>731,836,063.00</b>	<b>1,430,680,297.08</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	27,970,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,447,500.00	117,335,808.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	679,388,563.00	1,285,374,188.28
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>3,062,700.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,062,700.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>355,067,426.50</b>	<b>23,103,257,325.35</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>46,699,570.72</b>	<b>1,843,431,365.34</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	46,699,570.72	1,843,431,365.34
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(46,699,570.72)</b>	<b>(1,843,431,365.34)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>308,367,855.78</u></b>	<b><u>21,259,825,960.01</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>19,499,877,156.75</b>	<b>27,893,935,232.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,189,960.00</b>	<b>14,562,700.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>17,189,960.00</b>	<b>14,562,700.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>17,189,960.00</b>	<b>14,562,700.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	830,000.00	2,284,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,359,960.00	12,278,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>19,482,687,196.75</b>	<b>27,879,372,532.92</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>217,605,991.57</b>	<b>2,143,803,362.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,846,981.71	52,644,362.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,752,809,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,035,292.00	338,350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,723,717.86	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,265,081,205.18</b>	<b>25,735,569,170.92</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,265,081,205.18	25,735,569,170.92
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>19,136,949,811.75</b>	<b>26,830,252,984.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,136,949,811.75</b>	<b>26,830,252,984.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,405,113,748.75</b>	<b>23,719,351,589.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,386,633,324.52</b>	<b>12,850,742,037.06</b>
210101	Үндсэн цалин	3,417,704,063.00	5,155,967,887.24
210102	Нэмэгдэл	2,054,059,041.60	1,681,321,830.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	978,754,506.40	1,638,991,161.50
210104	Урамшуулал	833,239,879.52	864,488,488.68
210105	Гэрээт ажлын хөлс	3,102,875,834.00	3,509,972,669.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,411,838,600.00</b>	<b>1,501,446,856.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	993,516,100.00	1,029,039,708.23
210202	Тэтгэмжийн даатгал	104,580,500.00	136,163,622.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	83,664,400.00	66,653,691.49
210204	Ажилгүйдлийн даатгал	20,916,100.00	53,698,544.85
210205	Эрүүл мэндийн даатгал	209,161,500.00	215,891,289.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,552,810,181.83</b>	<b>2,029,446,458.18</b>
210301	Гэрэл, цахилгаан	256,465,360.20	281,219,108.02
210302	Түлш, халаалт	251,990,093.45	284,596,172.84
210303	Цэвэр, бохир ус	74,311,694.84	90,117,574.01
210304	Байрны түрээс	970,043,033.34	1,373,513,603.31
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>440,914,184.09</b>	<b>603,069,516.13</b>
210401	Бичиг хэрэг	165,416,925.00	259,573,890.00
210402	Тээвэр, шатахуун	23,127,800.00	51,491,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,934,519.09	128,271,289.13
210404	Ном, хэвлэл	-	4,808,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,434,940.00	158,924,437.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,298,000.00</b>	<b>23,222,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,298,000.00	23,222,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>459,936,476.00</b>	<b>497,516,124.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,398,800.00	48,193,600.00
210602	Тавилга	-	6,826,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,500,000.00	-
210604	Урсгал засвар	442,037,676.00	442,496,324.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>298,894,624.70</b>	<b>436,916,353.26</b>
210701	Гадаад албан томилолт	298,356,324.70	388,485,103.26
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	538,300.00	48,431,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,864,600,454.17</b>	<b>2,633,312,611.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,842,898,521.57	2,613,388,436.50
210803	Даатгалын үйлчилгээ	-	813,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	342,204.00	527,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	185,000.00	-
210807	Газрын төлбөр	21,174,728.60	18,583,961.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,988,187,903.44</b>	<b>3,143,679,633.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,988,187,903.44	3,143,679,633.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>-</b>	<b>62,944,895.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>-</b>	<b>62,944,895.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	62,944,895.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>731,836,063.00</b>	<b>3,047,956,500.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>731,836,063.00</b>	<b>1,430,680,297.08</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	27,970,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,447,500.00	117,335,808.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	679,388,563.00	1,285,374,188.28
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>1,617,276,203.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,617,276,203.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>362,927,345.00</u></b>	<b><u>1,063,682,248.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>362,927,345.00</b>	<b>1,063,682,248.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>362,927,345.00</b>	<b>1,063,682,248.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>362,927,345.00</b>	<b>1,063,682,248.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	362,927,345.00	1,063,682,248.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(362,927,345.00)</u></b>	<b><u>(1,063,682,248.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,756,685,081.13</b>	<b>27,020,616,846.25</b>	-	<b>91,227,282,834.54</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,756,685,081.13</b>	<b>27,020,616,846.25</b>	-	<b>91,227,282,834.54</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	308,367,855.78	-	308,367,855.78
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,756,685,081.13</b>	<b>27,328,984,702.03</b>	-	<b>91,535,650,690.32</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,756,685,081.13</b>	<b>27,328,984,702.03</b>	-	<b>91,535,650,690.32</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,885,538.34	-	2,885,538.34
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,756,685,081.13</b>	<b>27,331,870,240.37</b>	-	<b>91,538,536,228.66</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,885,538.34)	-	-	(2,885,538.34)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	21,259,825,960.01	-	21,259,825,960.01
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>26,449,980,907.16</b>	<b>37,753,799,542.79</b>	<b>48,591,696,200.38</b>	-	<b>112,795,476,650.33</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,842,259,400.00</b>	<b>25,747,069,170.92</b>	<b>1,095,190,229.08</b>	<b>95.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,842,259,400.00</b>	<b>25,747,069,170.92</b>	<b>1,095,190,229.08</b>	<b>95.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>25,145,606,700.00</b>	<b>24,281,414,278.84</b>	<b>864,192,421.16</b>	<b>96.6</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,365,659,100.00</b>	<b>12,850,742,037.06</b>	<b>514,917,062.94</b>	<b>96.1</b>
Үндсэн цалин	5,093,676,000.00	5,155,967,887.24	(62,291,887.24)	101.2
Нэмэгдэл	1,828,206,900.00	1,681,321,830.28	146,885,069.72	92.0
Унаа хоолны хөнгөлөлт	1,700,555,000.00	1,638,991,161.50	61,563,838.50	96.4
Урамшуулал	1,076,330,000.00	864,488,488.68	211,841,511.32	80.3
Гэрээт ажлын хөлс	3,666,891,200.00	3,509,972,669.36	156,918,530.64	95.7
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,592,144,000.00</b>	<b>1,501,446,856.71</b>	<b>90,697,143.29</b>	<b>94.3</b>
Тэтгэврийн даатгал	1,074,054,000.00	1,029,039,708.23	45,014,291.77	95.8
Тэтгэмжийн даатгал	142,241,000.00	136,163,622.33	6,077,377.67	95.7
ҮОМШӨ-ний даатгал	79,470,000.00	66,653,691.49	12,816,308.51	83.9
Ажилгүйдлийн даатгал	56,896,000.00	53,698,544.85	3,197,455.15	94.4
Эрүүл мэндийн даатгал	239,483,000.00	215,891,289.81	23,591,710.19	90.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,235,839,600.00</b>	<b>2,029,446,458.18</b>	<b>206,393,141.82</b>	<b>90.8</b>
Гэрэл, цахилгаан	360,000,000.00	281,219,108.02	78,780,891.98	78.1
Түлш, халаалт	360,000,000.00	284,596,172.84	75,403,827.16	79.1
Цэвэр, бохир ус	139,317,700.00	90,117,574.01	49,200,125.99	64.7
Байрны түрээс	1,376,521,900.00	1,373,513,603.31	3,008,296.69	99.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>608,190,700.00</b>	<b>599,519,516.13</b>	<b>8,671,183.87</b>	<b>98.6</b>
Бичиг хэрэг	260,268,300.00	259,573,890.00	694,410.00	99.7
Тээвэр, шатахуун	53,614,400.00	51,491,900.00	2,122,500.00	96.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,200,000.00	128,271,289.13	5,928,710.87	95.6
Ном, хэвлэл	4,808,000.00	4,808,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	155,300,000.00	155,374,437.00	(74,437.00)	100.0
<b>Нормативт зардал</b>	<b>5,540,000.00</b>	<b>3,422,000.00</b>	<b>2,118,000.00</b>	<b>61.8</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,540,000.00	3,422,000.00	2,118,000.00	61.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>952,990,000.00</b>	<b>952,081,824.00</b>	<b>908,176.00</b>	<b>99.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	240,000,000.00	239,605,854.00	394,146.00	99.8
Тавилга	237,500,000.00	237,439,646.00	60,354.00	100.0
Урсгал засвар	475,490,000.00	475,036,324.00	453,676.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>443,720,000.00</b>	<b>436,916,353.26</b>	<b>6,803,646.74</b>	<b>98.5</b>
Гадаад албан томилолт	389,500,000.00	388,485,103.26	1,014,896.74	99.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	54,220,000.00	48,431,250.00	5,788,750.00	89.3
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,347,773,200.00</b>	<b>2,331,024,352.50</b>	<b>16,748,847.50</b>	<b>99.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,311,432,800.00	2,311,100,177.50	332,622.50	100.0
Даатгалын үйлчилгээ	813,100.00	813,010.00	90.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	527,300.00	527,204.00	96.00	100.0
Газрын төлбөр	35,000,000.00	18,583,961.00	16,416,039.00	53.1
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,593,750,100.00</b>	<b>3,576,814,881.00</b>	<b>16,935,219.00</b>	<b>99.5</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	3,593,750,100.00	3,576,814,881.00	16,935,219.00	99.5

<b>ТАТААС</b>	<b>62,944,900.00</b>	<b>62,944,895.00</b>	<b>5.00</b>	<b>100.0</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>62,944,900.00</b>	<b>62,944,895.00</b>	<b>5.00</b>	<b>100.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	62,944,900.00	62,944,895.00	5.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,633,707,800.00</b>	<b>1,402,709,997.08</b>	<b>230,997,802.92</b>	<b>85.9</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,633,707,800.00</b>	<b>1,402,709,997.08</b>	<b>230,997,802.92</b>	<b>85.9</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	131,620,800.00	117,335,808.80	14,284,991.20	89.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,502,087,000.00	1,285,374,188.28	216,712,811.72	85.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>26,842,259,400.00</b>	<b>25,750,131,870.92</b>	<b>1,095,190,229.08</b>	<b>95.9</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>26,830,759,400.00</b>	<b>25,732,506,470.92</b>	<b>1,098,252,929.08</b>	<b>95.9</b>
Орон нутгийн төсвөөс	26,830,759,400.00	25,732,506,470.92	1,098,252,929.08	95.9
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>11,500,000.00</b>	<b>14,562,700.00</b>	<b>(3,062,700.00)</b>	<b>126.6</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	2,284,000.00	(784,000.00)	152.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	12,278,700.00	(2,278,700.00)	122.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,143,803,362.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,143,803,362.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>501,619,559.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,550,000.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,550,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,800,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>49,715,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,515,000.00
210602	Тавилга	21,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>403,619,559.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	403,619,559.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,935,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,935,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,642,183,803.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,970,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,970,300.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,614,213,503.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,614,213,503.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,143,803,362.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,143,803,362.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	52,644,362.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,091,159,000.00

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын тайланд төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитаар нийт 381,748.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,789.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 241,880.5 мянган төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 137,078.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.	1	43,183.0			1	43,183.0		
Үйл ажиллагааны чиглэл өөр ААН-ээр ажил гүйцэтгүүлж, төлбөр төлсөн.	1	52,500.0			1	52,500.0		
Вайлд Резорт ХХК-иар харьяа төсвийн байгууллагын 150 албан хаагчийг хоол /60.0 мянган төгрөг/, бичиг хэргийн зардал /23.0 мянган төгрөг/-тай сургалтад хамруулсан.	1	13,600.0			1	13,600.0		
Нийт 145 хүн оролцуулахаар төлөвлөсөн сургалтад 60 хүн оролцсон, БГД-ийн 7 давхрын хурлын зааланд болсон сургалтад түрээсийн төлбөр 6,860.0 мянган төгрөг төлж, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	18,837.5			1	18,837.5		
Баянгол Өв соёл арга хэмжээнд зарцуулахаар төсөв зарцуулах тушаал гарсан боловч гүйцэтгэлээр ямар зардалд зарцуулсан нь тодорхойгүй, төсөв үрэлгэн зарцуулсан.	1	19,900.0			1	19,900.0		
Дүүргийн ЗДТГ-ын болон харьяа хэлтсийн албан хаагчдад нэг багшийн 30 минутын сургалтын хөлс, түрээсийн төлбөрт ЗЗҮ-ээс хэт өндөр төлбөр төлсөн, ирцийн мэдээлэл байхгүй, фото зураггүй баримтаар гүйлгээ хийсэн байна.	1	14,960.0			1	14,960.0		
Бараа материалыг бөөн дүнгээр, нэр төрлийг тодорхой бус бүртгэсэн.	1	84,092.5					1	84,092.5
Бараа материалын нэршил тодорхой бус бүртгэсэн.	1	20,642.8					1	20,642.8
Тооллогын комисст хөрөнгө хариуцсан нягтлан бодогч, няравыг томилсон, актахаар санал болгосон бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцээгүй, шийдвэр гаргаагүй, тооцоог бодож акт үйлдээгүй.	1						1	
Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ын кодыг зөрүүтэй сонгосноос зөрүү үүсгэсэн.	1	32,343.1					1	32,343.1
Дүүргийн Засаг даргын нөөц сангаас тусдаа төсөвтэй улсын төсвийн байгууллагуудын албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж, урамшуулал хавтгайруулан олгосон.	1	78,900.0			1	78,900.0		
Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.	1				1			
Гадаад томилолтоор ажилласан албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан олгосон.	1	2,789.5	1	2,789.5				
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>381,748.4</b>	<b>1</b>	<b>2,789.5</b>	<b>8</b>	<b>241,880.5</b>	<b>4</b>	<b>137,078.4</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт 14,023.0 мянган төгрөгийн шатахуун их хэмжээгээр нөөцөлсөн, шатахууны нэгжийн үнэ, тоо хэмжээг буруу бүртгэсэн байна.	1	14,023.0					1	14,023.0
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	291,000.4					1	291,000.4
Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна.	1						1	
Шилэн дансны цахим хуудаст үндсэн хөрөнгө бүртгэх тухай байгууллагын даргын шийдвэрийг байршуулаагүй байна.	1						1	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>305,023.4</b>					<b>4</b>	<b>305,023.4</b>

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			